



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/152

Арвайхээр

Зөвшөөрөл олгох тухай

“Хүүхэд харах үйлчилгээний тухай” хуулийн 13.2, 13.3, 14.1, “Стандартчиллын үндэсний зөвлөл”-ийн MNS 6540:2015 стандарт, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны а/152 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах журам”-ын 2.1, 3.1.7, 3.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус суманд хүүхэд харах үйлчилгээ эрхлэх хүсэлт гаргасан иргэдийн өргөдөлийн дагуу 1 дүгээр багийн Засаг даргын дүгнэлтийг үндэслэн 1-50-12, 1-42-53 тоотод байрлах байр мөн иргэн Дэлгэррагчаагийн Алтанзаяа, Энхжаргалын Амаржаргал, Дидагийн Нармандах, Самдангийн Сүрэнхорлоо, Батсүхийн Уранзаяа нарт тус тус Хүүхэд харах үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгосугай.

2. Үйлчилгээний хэрэгжилтийн явц үр дүнд хяналт тавьж ажиллахыг СӨББайгууллагын арга зүйч /Ц.Отгонхорол/, харьяа багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ